

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2022 оны жилийн эцэс/**

2023 оны 03 дугаар сарын 01-ны өдөр

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 6 ангиллын 18 үзүүлэлтээр гүйцэтгэлтийг гаргасан байна.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ	
			2020	2022	2022	Хувь	Оноо
1	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)	хувь	41.1	45.0	44.0	97.8%	4.9
2	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг нэгтгэх төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх)	хувь	30.0	60.0	60.0	100.0%	5.0
3	Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ						
	Газрын тос (мян.бар)	бар	4,199.1	6,115.4	2,565.4	41.9%	2.1
	Нүүрс (сая тн)	сая тн	38.0	63.0	37.3	59.2%	3.0
	Зэсийн баяжмал (мян.тн)	мян.тн	1,270.0	1,670.0	1,189.8	71.2%	3.6
	Төмрийн хүдэр (сая тн)	сая тн	8.2	9.2	7.7	83.3%	4.2
	Алт (тн)	тн	19.0	22.0	19.4	88.1%	4.4
4	Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ						
	Газрын тос (мян.бар)	бар	4,198.8	6,054.2	2,605.9	43.0%	2.2
	Нүүрс (сая тн)	сая тн	25.0	40.0	31.8	79.5%	4.0
	Зэсийн баяжмал (мян.тн)	мян.тн	1,270.0	1,670.0	1,453.3	87.0%	4.4
	Төмрийн хүдэр (сая тн)	сая тн	8.2	9.2	4.7	51.4%	2.6
	Алт (тн) Монгол банканд тушаасан	тн	19.0	22.0	22.9	104.1%	5.2
5	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ						
	Үүнээс: ОХУ-аас	сая тн	1.9	2.1	1.8	85.7%	4.3
	Бусад улсаас	сая тн	0.1	0.1	0.1	100.0%	5.0
6	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл (тн)						
7	Катодын зэс 99%	тн	9,300.0	9,600.0	9,736.0	101.4%	5.1
8	Цахилгааны утас	тн	72.0	80.0	68.3	85.4%	4.3
9	Метал бэлдэц	тн	15,507.0	35,350.0	24,988.1	70.7%	3.5
10	Метал цувимал	тн	16,675.0	33,000.0	26,140.9	79.2%	4.0
УУХҮЯ-ны ЭЗНХҮ-ийн биелэлтийн ерөнхий үнэлгээ						78.4%	4.0

Тайлангийн хугацаанд газрын тосны олборлолт 41.9 хувь, экспорт 43.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь 2022 оны 06 дугаар сар хүртэл БНХАУ хилээ хаасан нь газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн болно.

Эдийн засгийн бусад үзүүлэлтүүд 51.4-104.1 хувийн биелэлттэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 79.4 хувьтай, 4.0 оноогоор дүгнэгдлээ.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга



Т.Баасанпүрэв

Танилцуулга боловсруулсан:
ХШҮДАГ-ын ахлах шинжээч



Х.Цэнд-Аюуш /2023.03.01/